# XI АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

Хугацаа: 60 минут | А хувилбар | Нийт — 40 оноо

Эхийг уншаад, даалгаврыг хийгээрэй. Цэнхэр балаар цэвэр гаргацтай бичнэ үү.

Шувуун саарал Д.Нацагдорж

Хөндий талын зэргэлээ мяралзан жирэлзэх нь холоос үзэхэд сонин. Хэдэн жижигхэн юм түүний дунд сүүмэлзэх нь яахин даруй танигдана.

Уудам газар дураар сэлгүүцэх хээр хөдөөгийн цэнгэл, хурдан морины ирэлзэн ирэх эр хүний бахдал, ойртон үзвэл хэдэн залуус морь тарлаж байна.

Сүрэнхүү саарал морины амыг арайхан тогтоож, овооны дэргэд буун, хөлсий нь хусаад, тамхи татан байх бөгөөд ташаа нь тэвхийж, хавирганы яс нь ярайсан, ялгуун саарал морь нь тогтож ядан, гоо сайхан толгойгоо ийш тийш сэжих нь агаарт дэгдэж, үүлэнд умбан алдмаар. Хоёр чихээ солбилзуулан, хааяа нэг шилгээж, эзнийхээ сэтгэлийг баясгана.

Энэ үед удаа дараа хүрч ирсэн хүмүүс түүнийг гайхан магтах бөгөөд шувуун саарал гэж нэрийдэн, Сүрэнхүүгээс шалж, өдий төдий залуу тарган морины үнэ хаялцана.

Сүрэнхүү морины толгойг илбэж худалдахгүй гэнэ.

Цугаар нэгэн зэрэг шувуун саарлын тухай яриа бололцоод оройн шар наранд зүг, зүг гэр гэртээ хоёр гурваараа нийлэлдэн ярилцан исгэрэлдэн одоцгооно.

Үүрийн хаяа гэгээрэхэд, хөмсөг мэт сар далд ороогүй, дэргэдүүр намрын хяруу гялтганаж, тэртээ уулын орой эрвийн сэрвийн үзэгдэнэ. Гэтэл Сүрэнхүү гэрээс гарч, морио барьж эмээллэн мордоод баруун зүг одов.

**Өглөөний нар гарахад, нэгэнт хэд хэдэн уул, голыг өнгөрчээ.** Сүрэнхүү хөндлөн сууж, холхи газрыг зорин энэ үдэш нэг юманд ярна.

1. Эхийг ямар хэв маягийн эх болохыг 5 өгүүлбэрээр баталж бичнэ үү? \10 оноо\
   \Жнь: Тоочимж, үйл явдлыг тоочин дүрсэлсэн гэх мэт\

   ......................................................................................................................................................
   ......................................................................................................................................................
   ......................................................................................................................................................
2. Эхийн тодруулсан өгүүлбэрийг бичиж, өб-н гишүүдээр зурж тодорхойлоорой?\ \4 оноо\
3. Дараах үгийн утгыг тайлбарлаж бичнэ үү? “үнэ хаялцана, тарлах.” \4 оноо\
4. Морины, гэгээрэхэд” үгсийн зөв бичгийн дүрмийг тайлбарлан бичээрэй? \4 оноо\
5. Тодруулсан бүтээврийн утга үүргийг тайлбарлаарай? \4оноо\
   “Хөмсөг **мэт**”, шинэ **үес тул**”

6.А. “Оноре Де Бальзак –н Эцэг Горио” зохиолын Эцгийн дүрийг тодорхойлж бичээрэй? \5оноо\
\Дүрийн хэв шинжээр нь\
Б.Зохиолын утга санааг хэлц хэллэгээр илэрхийлээрэй \4 оноо\

7.Галигыг үндэсний бичигт хөрвүүлээрэй. \5оноо\
“Ном-ун санг, анги тангхим хүмүс олагулан байиху гажар ном и унгшиба”

ХI АНГИЙН МОНГОЛ ХЭЛ БИЧИГ, УРАН ЗОХИОЛЫН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

Хугацаа: 60 минут Б Хувилбар Нийт — 40 оноо

Шувуун саарал Д.Нацагдорж

Хөндий талын зэргэлээ мяралзан жирэлзэх нь холоос үзэхэд сонин. Хэдэн жижигхэн юм түүний дунд сүүмэлзэх нь яахин даруй танигдана.

Уудам газар дураар сэлгүүцэх хээр хөдөөгийн цэнгэл, хурдан морины ирэлзэн ирэх эр хүний бахдал, ойртон үзвэл хэдэн залуус морь тарлаж байна.

Сүрэнхүү саарал морины амыг арайхан тогтоож, овооны дэргэд буун, хөлсий нь хусаад, тамхи татан байх бөгөөд ташаа нь тэвхийж, хавирганы яс нь ярайсан, ялгуун саарал морь нь тогтож ядан, гоо сайхан толгойгоо ийш тийш сэжих нь агаарт дэгдэж, үүлэнд умбан алдмаар. Хоёр чихээ солбилзуулан, хааяа нэг шилгээж, эзнийхээ сэтгэлийг баясгана.

Энэ үед удаа дараа хүрч ирсэн хүмүүс түүнийг гайхан магтах бөгөөд шувуун саарал гэж нэрийдэн, Сүрэнхүүгээс шалж, өдий төдий залуу тарган морины үнэ хаялцана.

Сүрэнхүү морины толгойг илбэж худалдахгүй гэнэ.

Цугаар нэгэн зэрэг шувуун саарлын тухай яриа бололцоод оройн шар наранд зүг, зүг гэр гэртээ хоёр гурваараа нийлэлдэн ярилцан исгэрэлдэн одоцгооно.

**Үүрийн хаяа гэгээрэхэд, хөмсөг мэт сар далд ороогүй,** дэргэдүүр намрын хяруу гялтганаж, тэртээ уулын орой эрвийн сэрвийн үзэгдэнэ. Гэтэл Сүрэнхүү гэрээс гарч, морио барьж эмээллэн мордоод баруун зүг одов.

Өглөөний нар гарахад, нэгэнт хэд хэдэн уул, голыг өнгөрчээ. Сүрэнхүү хөндлөн сууж, холхи газрыг зорин энэ үдэш нэг юманд ярна.

1. Эхийг ямар хэв маягийн эх болохыг 5 өб-ээрээр тодорхойлж бичээрэй? \10 оноо\

   \Жнь: Тоочимж, үйл явдлыг тоочин дүрсэлсэн гэх мэт\

   ..............................................................................................................................................

   ..............................................................................................................................................

   ..............................................................................................................................................

2. Эхээс тодруулсан өгүүлбэрийг өгүүлбэрийн гишүүдээр зурж тодорхойлоорой? \4 оноо\

3. **"илбэж**, Сүрэнхүүгээс **шалж"** тодруулсан үгсийн утгыг тайлбарлаарай? \4 оноо\

4. **"Гэ"** " гэтэл"холбох бүтээврийн утгыг тайлбарлаарай? \4 оноо\

5. Морио ,барьж үгсийн зөв бичих дүрмийг тайлбарлаарай \4оноо\

6. "Эцэг Горио зохиолын" Охидын дүрүүдийг тайлбарлаж бичээрэй? \ 5 оноо\

Б. Энэхүү зохиолын сэдвийг тодорхойлоорой? \4 оноо\

7. Үндэсний бичит хөрвүүлээрэй? \5оноо\

   "Ном унгшиху орчин хэтү хурца биши гэрэл-тэй баийдаг."